

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2019.09.25, №12 (116)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**

№498

Д.Жаргалсайхан

Эдийн засагч, нийтлэлч

ЖДҮ БОЛ ХӨГЖЛИЙН ТОЛЬ



НИЙТЛЭЛ

Г.Нарантуяа

Олон улсын эрх зүйч (PhD),
Австралийн Үндэсний Их
Сургуулийн зочин судлаач

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛЫГ

Эсэргүүцэхийн учир

III НҮҮРТ

ДеФакто **ТОЙМ**

➤ МОНГОЛ УЛСЫН НИЙТ
ГАДААД ӨР

➤ МОНГОЛ УЛС ДИЖИТАЛ
ШИЛЖИЛТЭД БЭЛЭН ҮҮ?

VII НҮҮРТ



Эдийн засгийн өсөлт ба эдийн засгийн хөгжил нь ялгаатай ойлголтууд. Өсөлт болгон хөгжил биш. Харин хөгжил бол өсөлт. Хөгжилд өсөлт чухал болохыг Английн эдийн засагч Пол Коллер “Адагт үлдсэн тэрбум” номондоо харуулжээ. Эдийн засаг хөгжихгүй бол ядуурал буурахгүй гэдгийг тэр баталсан юм.

Манай эдийн засаг 90-ээд оноос өссөн ч, хөгжил зөвхөн 2010 оноос хойш эхэлсэн. Энэ хөгжлийг авчирсан ганц салбар бол уул уурхай. Гэхдээ энэ хөгжил ганцхан салбараас хамааралтай учир тогтворгүй, баталгаагүй гэдгийг эдийн засгийн хоёр ч удаагийн

хамрал харуулав. Экспортын 80 хувийг бүрдүүлдэг уул уурхайн салбарт, хөрөнгө оруулалттай нь зэрэгцүүлэхэд харьцангуй цөөн буюу 58 мянган хүн ажиллаж байна.

Хамгийн олон хүн ажиллаж, эдийн засагт тус бүрдээ бага боловч, хамтдаа хамгийн том хувь нэмэр оруулдаг ААН бол жижиг дунд үйлдвэрүүд (ЖДҮ) юм. ЖДҮ бол эдийн засгийн ноён нуруу ч гэдэг. Тийм ч учраас тухайн орны ЖДҮ ямар бүтээгдэхүүн, үйчилгээ хүргэж, ямар техник, технологи ашиглаж, ямар бүтээмжтэй ажиллаж байгаа нь улсынх нь хөгжлийн толь болдог. Манай ЖДҮ-ийн дүр төрх ямар байна вэ?

ЖДҮ-ИЙН ОДОО БАЙГАА ДҮР ТӨРХ

Монголбанкны судалгаанд (Д.Ган-Очир ба бусад, 2018) төрд бүртгэлтэй 80-аад мянган ААН-ээс 60 мянга нь ЖДҮ ангилалд ордог гэжээ. ЖДҮ-үүдэд улсын ажиллах хүчний 43 хувь буюу 900-аад мянган хүн ажилладаг атлаа ДНБ-ий дөнгөж 17, экспортын 2.3 хувийг бүтээдэг. Монголын ЖДҮ-үүд бүтээгдэхүүн, үйчилгээгээ экспортод гаргаж чадахгүй байна. Тоног төхөөрөмж, тодорхой түүхий эдээ гадаадаас валютаар аваад, дотооддоо төгрөгөөр борлуулдаг учир ханшийн зөрөөнөөс тэдний ашиг өсөх, бизнесээ тэлэх боломж нь ихээхэн хамаардаг.



▶ Монголын компаниудын, түүний дотор ЖДҮ-ийн тоо мэдээлэл бүрэн бус, тодорхойгүй учир судалгаа хийхэд хүндрэлтэй. АХБ-ны судалгаагаар (Asia SME Finance Monitor 2014. Page 102) 2013 оны байдлаар 50-аас цөөн ажиллагсадтай компани 97,762 байсан нь нийт бүртгэгдсэн компанийн 98.2 хувийг эзэлжээ. Гэхдээ бүртгэлтэй компаниудын 90.6 хувь нь 10-аас цөөн ажиллагсадтай микро компаниуд. Монголын бүртгэгдсэн компаниудын тал нь юу ч хийдэггүй, хаагдсан аж.

1990 оноос хойш ЖДҮ-ийг хөгжүүлэх талаар хамгийн их ярьсан ч, 30 жилийн дараа хүлээлтээс илт доогуур байна. Төрөөс ЖДҮ-г эхэндээ зөвхөн гадаад, дотоодын зээл, тусламжаар дэмжих гэж оролдож байлаа. Зөвхөн 2007 онд л Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай анхны хууль батлагджээ. Түүнээс хойш энэ хуулийг шинэчлэх гэж оролдсон ч, УИХ батлахгүй өдийг хүрчээ.

Энэ хуулиар л 200-аас цөөн ажиллагсадтай, эргэлт нь жилд 1.5 тэрбум төгрөг хүрдэггүй ААН-ийг ЖДҮ гэж заасан. Гэвч амьдрал дээр салбар, салбараар ялгаатай тооцдог болов.

- Аж үйлдвэрийн салбарт, 20-оос цөөн ажиллагсадтай, жилд 250 сая төгрөгөөс бага эргэлттэй бол ЖДҮ гэж тооцож байна.
- Үйлчилгээний салбарт 50-аас цөөн хүнтэй, 1 тэрбум төгрөгөөс бага эргэлттэйг ЖДҮ гэх болов. Аль салбарын ЖДҮ-г яаж тооцоод, гааль, худалдааны татвараас хөнгөлж чөлөөлөх нь хууль тогтоогчдод илүү ашигтайгаас хамаардаг. Энэ ойлгомжгүй байдлаас болоод ЖДҮ-ийн статистик мэдээлэл гаргаж чадахгүй байна.

Дээрх Монголбанкны судалгаагаар ЖДҮ бизнес эрхлэгчдэд тулгараад буй хамгийн том хоёр асуудал бол санхүүжилт ба хүний нөөцийн чадавч гэж гарчээ. ЖДҮ-г хөгжүүлэх талаар төр засаг нэрэн дээрээ түмэн бодлого явуулж, тэрбумаар нь төгрөг зарцуулдаг ч, нидэр дээрээ яг хэнд очдог байсныг саяхан иргэд мэдсэн. Гурван хувийн хүүтэй, ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн зээлийг УИХ-ын 76 гишүүний 55 нь өөрийн болон холбоотой этгээдийн компаниудад олгуулаад байна. Тэдэнтэй хариуцлага тооцож чадахгүй, жилийн дотор хэрэг замхарч мартуулах чиглэлд явж байна. Сүүлийн арван жилд энэ сангаар 7536 зээлдэгчид 835 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосны ихэнхийг төрийн түшээд өөрсдөө авчихсан гэвэл хэн ч гайхахгүй болжээ.

Төр засаг нь ийм байгаа улсад ЖДҮ эрхлэгчид боловсон хүчнээ өөрсдөө бэлдэх боломж хомс, боловсрол, ялангуяа мэргэжил техникийн дадлага нь бизнесийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байгааг бас л гайхах шаардлагагүй юм. Бизнес, судалгаа шинжилгээ хооронд нягт уялдаа холбоотой байж л улс орны хөдөлмөрийн бүтээмж нэмэгддэг.

ДҮР ТӨРХӨӨ ӨӨРЧЛӨХ НЬ

Толин дахь дүрсээ өөрчлөхийн тулд, дүр төрхөө л өөрчлөхөөс өөр сонголтгүй. ЖДҮ-ийг дэмжихдээ зөвхөн зээл, тусламж гэхээс илүү хатуу ба зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай. Зам тээвэр, харилцаа холбоо, цахилгаан эрчим хүч зэрэг хатуу дэд бүтэц чухал үүрэгтэй. Зөөлөн дэд бүтцийг жишээ нь солилцооны (хэлцлийн) зардлаар (transaction cost) хэмжиж, сайжруулж болно. Энэ зардал өндөр бол солилцоо удаан, эсвэл бүр хийгдэхгүй, эдийн засгийн эргэлт зогсоно. Жишээ нь ЖДҮ-ийн зээлийн барьцаа бүрдүүлэхэд дунджаар 2.4 сая, төрийн болон бусад хөнгөлттэй зээлд хамрагдахад 521 мянган төгрөгийн зардал гардаг (ERI судалгаа. 2017) ажээ. Дээр нь төрийн байгууллагуудтай харилцахад зарцуулсан цаг хугацаа (бэлэг сэлт, авлига гэх мэт) нэмэгдэнэ. Төрийн эдийн засгийн байгууллагууд институцийн хувьд өсч хөгжиж чадвал бизнесийн солилцооны зардал эрс буурдаг.

Бусад орны түүхээс харахад бүтээгдэхүүний үнэ цэнийн хэлхээний тодорхой хэсэгт ЖДҮ оролцож төрөлжин, өсч томрсон байдаг. Япон, Солонгосын том компаниудыг

дагаад олон арван мянган ЖДҮ хөл дээрээ боссон. Жишээ нь Тоёото машины үйлдвэрлэлийг тойроод бэлтгэн нийлүүлдэг олон компани бий болж, өсч томорсоор бие даасан Тоёото хотыг бүрдүүлжээ.

Монголд харин том компаниуд жижгүүдээ унагаж байна. Өөрийн банк, газар тариалан, үйлдвэрлэл, хүнс, бэлэн хоол бас авто машин зардаг, ТВ сонинтой том компаниудтай ямар ч жижиг компани өрсөлдөж чадахгүй, дампуурч байна. Бусаддаа боломж олгож, охин компаниудаа ажиллагсад нь хувьчлаад, өөрийн үндсэн бизнест төвлөрч буй компаниуд ч бас байна. Монголд архины болон ноолуурын салбарт монополь тогтож байна. Том компани, банкууд бүх бизнест орохоо зогсоож төвлөрөх, томрох, олон улсын зах зээл дээр гарах цаг нь болсон. Тэгвэл ЖДҮ ч тэлэх боломж гарч, ажлын байр нэмэгдэхийн хэрээр ядуурал буурахад нөлөөлнө.

Гэхдээ аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын үр дүнд ЖДҮ-т шинэ боломж бий болж эхэллээ. Олноор биш, тухайн хэрэглэгчид тааруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх цаг ирж байна. Мөн 3D принтерийн

технологи ашиглах боллоо. Аж үйлдвэрийн хувьсгалаар үйлдвэрлэл, түгээлтийн дахин хуваарилалт явагдаж байгаа нь ЖДҮ эрхлэгчдийг түргэн, ухаалаг суралцаж, олон улсын зах зээлд гарах боломж олгож байгаа юм. Төр засаг ч гэсэн энэ төрлийн зөөлөн дэд бүтцийг бүрдүүлэх шаардлага тулгарлаа. Шинэ бизнес эхлүүлж байгаа ЖДҮ эрхлэгчдэд эхний хэдэн жилд нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж болох юм. Дотоодод үйлдвэрлэх боломжтой ч, импортоор авч буй бүтээгдэхүүнийг татварын болон бусад аргаар зохицуулж, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, дэмжих шаардлагатай.

ЖДҮ эрхлэгчид арилжааны банкуудаас санхүүжилт авдаг. Тэд ихэвчлэн 1-5 жилийн хугацаатай, 10-50 сая төгрөгийн санхүүжилт хүсдэг. Монголбанк зарим орны жишгээр ЖДҮ-т олгож буй зээлийн заавал байлгах ёстой нөөцийг бууруулах, тэр хэмжээгээр банк ч зээлийн хүүгээ бууруулах арга хэмжээ авч болох юм.

ЖДҮ хөгжиж томрох тусам улс орон хөгждөг.



НИЙТЛЭЛ

Г.НАРАНТУЯА

Олон улсын эрх зүйч (PhD), Австралийн
Үндэсний Их Сургуулийн зочин судлаач

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛЫГ Эсэргүүцэхийн учир

Ерөнхийлөгчийн засаглал монголд тохирохгүй, хичнээн гайхамшиг байсан ч бид энэ тухай ярих шаардлагагүй. Учир нь харьцангуй их эрх мэдлийг, харьцангуй тогтвортойгоор нэг хүнд шилжүүлдэг ийм засгийг дарангуйлалд урвуулахгүйн тулд бат бөх, ул суурьтай хяналтын механизм ажилладаг. Тийм хяналт Үндсэн хуульт байгууламжаас илүү өргөн хүрээнд, нийгмийн мөн чанарт шингэж оршдог. Харин бидэнд тийм орчин нөхцөл, тийм хяналтыг хэрэгжүүлэх тэнхээ өнөөдөртөө лав байхгүй. Яагаад гэдгийг энд тайлбарлана. Үүний зэрэгцээ дэлхийн улс төрийн өнөөгийн уур амьсгал ч нэг хүний засаглал “буруу замаар будаа тээх” өндөр эрсдэлтэй байгааг харуулж байна. Энэ талаар нийтлэлийн хоёрдугаар хэсгээс уншаарай.

— НЭГДҮГЭЭР ХЭСЭГ —

Ерөнхийлөгчийн засаглалыг дэмжигсэд АНУ-ын тогтолцоог шагшин магтах аж. Гэхдээ тэд мөсөн уулын зөвхөн оройн хэсгийг харжээ. Суурийг нь ойлгохын тулд түүх ярих хэрэгтэй болно. АНУ-ын төрийн тогтолцоо зөвхөн Үндсэн хууль батлагдсанаар бий болоогүй юм. Тэр засаг, тэрхүү нийгмийн мөн чанарыг ойлгохын тулд наад зах нь 1066 онд Нормандчууд Английг эзлэж, газрыг нийгмийн зэрэг зиндаа харгалзан эзэмшүүлдэг түрээсийн тогтолцоо буюу феодализмийг бий болгосноос эхлэж харах учиртай. Энэ цаг үеэс АНУ-ын төрийн тогтолцооны өвөг болох Английн орчин үеийн төр, эрх зүйн тогтолцоо бүрдэж эхэлсэн.

Тооны хувьд цөөхөн, хүч багатай боловч дасан зохицох чадвар сайтай Нормандчууд Английг засаглахдаа шинээр захиргааны байгууллага, хууль цаазыг бий болгохгүйгээр Англи-Саксоны төрийн байгууллагуудын хуучин суурийг өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн өөрчилсөн юм. Англид эзэн суухад Нормандчуудын түшиц нь үнэнчээр дагахаа илэрхийлж, газрын эзэд болсон Англи-Саксоны язгууртнууд, түшмэлүүдээс илүүтэйгээр эзэд, ноёдынхоо шударга бус байдалд гоморхсон ард олон байв. Нормандын хаадууд ардуудад ойрхон байж, гомдол, маргааныг нь өөрийн биеэр, харьцангуй шударгаар (ижил тохиолдлуудыг адил шийдэж) шийдвэрлэх замаар засаглах эрх, нөлөөгөө бэхжүүлж байсан нь улмаар парламентат ёс, нийтийн эрх зүй (common law) бий болох нөхцлийг бүрдүүлжээ. Энд

Английн эрх зүйн тогтолцооны түүхийг хүүрнэвэл бас чухал дүр зураг харагдах боловч уншигч таныг залхаахгүйн тулд феодалийн тогтолцоо, багахан орон зайд нийгэмшиж амьдардаг олон хүн, эзэн хааны ард олонд ээлтэй байх шаардлага, тэдгээрээс үүдэлтэй зуун дамжиж хөгжсөн нарийн, төвөгтэй хууль эрх зүйн тогтолцооны үр дүнд хууль, дэг журмыг эрхэмлэх сэтгэлгээ Англичуудын соёлын ДНХ-ийн нэг хэсэг болсон гээд орхиё.

Ямар ч эрх мэдэл ялзрах хандлагатай байдаг¹ тул эрх мэдлийг хязгаарлах дэвшилтэт институтээ (парламент ба шүүх), тогтвортой хуулиа тэдгээрийг төрүүлсэн Нормандын угшлын хаадын дур зоргоос хамгаалах шаардлага цагийн эрхээр Англичуудад бий болж байв. Ийнхүү 1215 онд Магна Карта (Magna Carta)², 1689 онд Эрхийн Билл (Bill of Rights)³, 1701 оны Эвлэрлийн тухай хууль (Act of Settlement)⁴ батлагджээ. Хязгаартай эрх мэдэл, маргааныг ашиг сонирхлоос ангид шийдвэрлэхийн чухлыг зүрх, тархиндаа бат ойлгосон Англичуудын туршлага таван зууныг туулан сая цаасан дээр буув. Өнөөдөр ч Англид эртний эдгээр баримт бичгээс өөр бичигдмэл Үндсэн хууль байдаггүй. Австралийн төрийн тогтолцоонд хамгийн их эрх мэдэлтэй субъект бол Ерөнхий сайд. Харин Ерөнхий сайд гэсэн үгийг Австралийн Үндсэн хуулиас эрээд та олохгүй. Тэнд гүйцэтгэх засаглалын ажил хуулиар гэхээсээ уламжлал, сэтгэлгээ, соёлоор зохицуулагддаг.

ОДОО АНУ-ЫН ТУХАЙД

1606 онд нэгдүгээр Жэймс хаан Плаймауд, Лондон компаниудад шинэ тивд байнгын колони байгуулах зөвшөөрлийг өгснөөр Америкийн колончлол эхлэв. АНУ байгуулагдах хүртэл 180 орчим жилд Английн 13 колони өлгий нутгаасаа өвлөсөн засаг захиргаа, эрх зүйн үндсэн дээр харьцангуй бие даан оршиж байлаа. Гэвч феодалийн тогтолцооны утгыг алдуулсан шинэ тивийн өргөн уудам, эзэнгүй газар, харьцангуй эрх чөлөө зэрэг нь өдөр тутмынх нь амьдралд нөлөө багатай боловч хөдөлмөрийнх нь үр шимийг хуу хамдаг хааны засгийг эсэргүүцэх сэдлийг колонийн иргэдэд төрүүлсээр байв. Өөрийн эрхээр амьдарч болох байтал яагаад эзэн хааны боол хэвээр үлдэх гэж? энэ асуултын хариулт болж “The American creed” буюу “Америк маягийн итгэл үнэмшил” колонийн жилүүдэд боловсорсон юм. Эрх чөлөөний хүсэл тэмүүлэл хувьсгалд (1765-1783) хүргэв, дайны дараа Үндсэн хууль (1788) батлагдаж, АНУ мэндлэв. Энэ тухай АНУ-ын хоёр дахь Ерөнхийлөгч Жон Адамс “Америкийн хувьсгал эхлээд хүмүүсийн оюун санаа, зүрх сэтгэлд гарсан юм” хэмээн бичиж үлдээсэн нь бий.

АМЕРИК МАЯГИЙН ИТГЭЛ ҮНЭМШИЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Товчхондоо, чөлөөт байдал (liberty), тэгш байдал (equality), бие даасан, хараат бус хувь хүн байх (individualism) болон өөрсдөө засаглах (self-government) гэсэн ойлголтуудыг Америк итгэл үнэмшил багтаадаг⁵. Чөлөөт байдал нь дарангуй төрөөс ангид байхыг, тэгш байдал нь нийгмийн бүх гишүүд үнэ цэнэ, эрхийнхээ хувьд адил тэгш байхыг, хувь хүн байх нь эдийн засгийн хувьд хараат бус, орон зай нь халдашгүй байхыг, өөрсдөө засаглах нь төрийн бодлогод үг, үзэл бодлоо тусгуулах боломжтой байх нөхцлүүдийг шаарддаг. Эзэн хаант засгийн дарангуйллыг эсэргүүцэж үүссэн улс төрийн олонлог учраас эрх мэдэлд болгоомжтой хандах, түүнийг хянах соёл Английн колони асан бусад улсуудынхаас ч өндөр. Ийм соёл, сэтгэлгээний суурин дээр өнөөдрийн АНУ өндийсөн. Нийтлэг үндэс угсаагүй энэ улсын иргэдийг эдгээр итгэл үнэмшил л Америк хүн болгодог. Соёл, спортын үйл ажиллагаа, орон нутгийн дунд сургуулийн хурал цуглаанаас эхлээд төрийн том ёслолоор үйлдэгддэг зан үйл бүхэлдээ эдгээр итгэл үнэмшлийг америкчуудын тархи, зүрхэнд суулгасаар ирсэн.

АНУ-ын Үндсэн хуулийг боловсруулах, холбооны засгийн бүтцийг зураглахад америк итгэл үнэмшил “алтан гадас” болж байв. Тийнхүү бүтээсэн засаг нь мөн эдгээр итгэл үнэмшлийг биежүүлэхэд хөтөч болох учиртай байлаа. Мэдээжийн хэрэг тийм архитектурыг холоос хайх шаардлага АНУ-ын Үндсэн хуулийн эхийг боловсруулагчдад байгаагүй. Төрийн эрх мэдлийг хуваарилах онолын Библи болох “Хуулиудын амин сүнс”-ийг Барон де Монтескье английн төрийн тогтолцооноос ургуулан бичсэн гэх юм билээ. Хэдийгээр америкчууд эрх чөлөөг максимум байдлаар хамгаалж чадах засгийг зураглахыг хичээсэн ч гарал үүслээсээ хол явж чадаагүй юм гэсэн санааг судалгааны нэг бүтээлээс дээх нь үед уншсан санагдана. Эзэн хааныг ерөнхийлөгчөөр сольсон нь харьцангуй уламжлалт хандлага боловч түүнийг хянах төрийн байгууллагуудын цогц тогтолцоог хуульчлан бүрдүүлсэн нь тухайн үедээ маш том дэвшил байсан. Гэвч тэр цагаас хойш 250 шахам жил өнгөрчээ.

**ХҮЧТЭЙ ЕРӨНХИЙЛӨГЧ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛДЭГ ГҮЙЦЭТГЭХ
ЗАСАГЛАЛЫГ ПАРЛАМЕНТ, ШҮҮХ, ХУУЛИАС ГАДНА НИЙГЭМ
НЬ, СОЁЛ НЬ, СЭТГЭЛГЭЭ НЬ ХЯНАДАГ ЮМ. ХЯНАХ ЁСТОЙГОО
УХАМСАРЛАСАН ОЛОН НИЙТ, ХЯНАГДАХ ҮҮРГЭЭ ОЙЛГОДОГ
УЛС ТӨРЧИД ТЭР ТОГТОЛЦООГ АМИЛУУЛДАГ.**

Нүдэнд харагдахгүй, хүний үйлдлийг тэр бүр яв цав тодорхойлохгүй ч соёл, хандлага, дадал хэмээгч зүйлс зөв, бурууг шүүх нийгмийн хэмжүүр болж, аливаа сонголтын учир шалтгаан болдог. Америк итгэл үнэмшил АНУ-ын төрийн бодлогыг хэрхэн залдгийг олон жишээнээс харж болно. Европын чөлөөт, ардчилсан дэглэмтэй улс орнуудтай харьцуулахад АНУ-ын нийгмийн халамжид зарцуулдаг төсөв харьцангуй бага, гэвч боловсролд зарцуулдаг төсөв нь их. Учир нь бусдын дэмжлэгийг авах зайлшгүй шаардлагатайгаас бусад үед хувь хүн өөрийгөө бүрэн хариуцах ёстой, харин хүн бүр амжилтад хүрэх тэгш боломжтой байх ёстой учраас чанартай боловсрол хүн бүрт хүртээмжтэй байх ёстой гэсэн нийгмийн итгэл үнэмшил эдгээр бодлогын цаана бий. Иргэний эрх, эмэгтэйчүүдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хөдөлгөөнүүд амжилтад хүрч, АНУ-г өөрчилж байгаагийн сэтгэлгээний суурь нь тэгш байдлын зарчим. Хүн бүр тэгш байх ёстой нийгэмд нэг хэсэг нь тэгш бус амьдарч байгааг эсэргүүцсэн тэмцлийг америкийн нийгмийн олонх нь итгэл үнэмшлээрээ дэмжсэн учраас байдал өөрчлөгдөж байгаа юм.

ХАРИН БИД ХЭН БИЛЭЭ?

Монгол мөрөөдөл ч юм уу, оюун санааны талаасаа бид хэн болох, хэн байхад тэмүүлэх ёстойг зааж зурсан итгэл, үнэт зүйлсийн томьёолол бидэнд байхгүй. Харин бид ямар соёл, сэтгэлгээ, дадалтай улс вэ гэдгийг эргэцүүлэхийг хичээсэн оролдлого хэдэн зуу биш юм гэхэд хэдэн арав бий⁶. Нэгэнт ихээхэн задгай, барьцгүй асуудал учраас зөвхөн энэ нийтлэлийн агуулгад хамааралтай соёл, оюун санааны асуудлыг л товчхон, бүдүүлэгдүү сануулъя. Бидэнд хуулийг эрхэмлэх, төрийн эзэн гэдгээ ухамсарлаж, эрх мэдлийг хянах, хувийн орон зайны халдашгүй байдлыг хамгаалах соёл, дадал, итгэл үнэмшил, хандлага бий юу? Бид олиггүйдээ биш, гагцхүү бид өөр түүхтэй, өөр орчинтой, өөр философийн нөлөө бидэнд хавьгүй их учраас оюун санааны тийм ДНХ маньд байхгүй. Байхгүй юу байхав, сүүлийн 30 жил бий болгохоор ядаж байна. Гэхдээ маш хэврэг.

Англиас төрсөн улс орнууд хэдэн зууны туршид өөрийн жамаар хөгжсөн соёл, сэтгэлгээний суурийг өвлөж, нүүдэллэн суурьшсан газрынхаа онцлог, үүссэн хөгжлийнхөө түүхээр нөхцөлдсөн өөр өөрийн өвөрмөц сэтгэлгээ, соёлыг бий болгосон. Угшил нэг боловч ондоошил бас их бий. Хамгийн гол нь тэдний соёл сэтгэлгээ органикаар хувьссан.

Харин? 20 дугаар зууныг Манжийн хамжлагаар эхэлсэн наш народ хувь заяаны эрхээр дэлхийн хоёр дахь социалист улс болов. Намын дарангуйллыг эцэслэх гэсэн олон нийтийн хүсэл, Зөвлөлт засгийн нөлөөг халах эрх баригчдын сонирхол нэгдэж, ардчилсан чөлөөт нийгмийг сонгов. Бидний соёл, сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэл ганцхан зууны дотор гурван удаа огцом, эрс өөрчлөгдсөн.



Гэрэл зургийг зохиогч хэдэн жилийн өмнө нийгмийн сүлжээнээс татаж авч, хадгалсан болно. Зурагчны утга төгс илэрхийлэлд талархаж, бүтээлийг нь ашиглах зөвшөөрөл хүсч байна. Зөвшөөрөл өгөхөөс татгалзвал Дефакто газет сонины редакцтай холбогдоно уу.

- Улаанбаатарын гудамжинд Буддын сүм, социализмийн ёотон маягийн орон сууц, капиталист шилэн барилгыг давхцуулан харж болно. Үүний адилаар бидний оюун санаанд өнгөрсөн хийгээд өнөөдрийн үнэт зүйлс холилдон эмх замбараагүй оршиж байгаа.
- Их монголын эзэнт гүрнээс улбаатай төрийг дээдлэх үзэл, Буддын шашны хүлцэнгүй философи, намаас айж, даргыг шүтэж явсан социализмийн туршлага бидний ой санамжид амь бөхтэй бий.
- Уудам орон зайд нүүдэллэн амьдарч ирсэн, өдөр тутмын амьдралд нь төр, хуулийн оролцоо харьцангуй бага байсан учраас бидэнд хуулийг сахихын чухлыг чөмгөндөө тултал ойлгох туршлага байсангүй. Социализмийн үед даргын үг хууль, хууль харин гууль байв.
- Саяхныг хүртэл өмгөр эсгий гэртээ гурван үеэрээ шамбааралдан амьдарч ирсэн маниус хувийн орон зайн халдашгүй байдал манатай. Цөөхүүлээ учраас аймаг хошуугаараа хамаатан шахуу, танилын халуун нүүрний илчинд зүй ёс, хууль ёс хайлж урсах нь элбэг⁷.
- Багштай маргах нь битгий хэл, асуулт асуувал заримдаа бурууддаг сургуулийн хүмүүжилтэй бид харьцангуй эрх мэдэлтэй ганц бүдүүн даргатай болчихоод түүнийгээ улалзуулж барах уу? 45-аас дээш настай, социалист ухамсрын бүтээгдэхүүн байх өндөр магадлалтай дарга маань ард түмний үйлчлэгч гэдгээ гүн бат ухамсарлаад улалзаад, учирлаад зогсож байх болов уу? Ихээхэн эргэлзээтэй шүү. Одоогийн

овоо даруулгатай даргаасаа бид чинь хариуцаж байсан дэд бүтцийн төслүүдийнх нь тухай битгий хэл хань ижил нь хэн болохыг ч асууж чадахгүй л яваа туулайнууд шүү дээ. Уул шугамандаа төрийн тэргүүний гэр бүлийн амьдрал нийтэд ил байж, түмэн олон ямар хувь хүнд итгэж, удирдуулснаа хянадаг. Хүний албан дүр, гэрийн дүрээс өөр байх нь олонтаа. Аль алиных нь зах зухыг мэдэрч байж удирдагчаа бид арай дээр танина.

АНУ-ын төрийн архитектурыг магтах яахав. Тэр барилгын суурь, түүнийг барьсан материал нь бидэнд алга. Төвлөрсөн эрх мэдлээс үүдэн гарах эрсдлийг бид үүрч чадахгүй. Даахгүй байж, булуу хураахаа болих уу даа, хампаануудаа?

Үргэлжлэл бий
2019 оны 9-р сар

- ¹ 19 дүгээр зууны Английн улс төрч Лорд Актоны “Power tends to corrupt. Absolute power corrupts absolutely” буюу “Эрх мэдэл ялзрах хандлагатай байдаг, хязгааргүй эрх мэдэл найгүй ялзардаг” гэсэн алдарт ишлэлийг сануулав. Эрх мэдэлд хүрсэн хүний ёс зүй ихэвчлэн доройтдог гэсэн аксиоматик ойлголттой учир Англиас төрсөн улс орнууд сайн удирдагчийг хайхаас илүүтэй түүнийг хянах сайн тогтолцоо ажиллуулахыг зорьдог.
- ² Эзэн хааны эрх мэдлийг хязгаарласан хууль зүйн анхны баримт бичиг.
- ³ Улс төрийн эрх, парламентийн засаглалыг баталгаажуулсан баримт бичиг.
- ⁴ Английн хаан ширээг залгамжлагчийн талаарх маргааныг шийдвэрлэсэн энэ баримт бичгийн өөр нэг түүхэн ач холбогдол нь шүүхийн хараат бус байдлыг баталжуулсан явдал юм.
- ⁵ The American creed гэх агуулгыг улс төрчид, судлаачид янз бүрээр тодорхойлсон нь бий. Бусад хувилбартай харьцуулахад товч, тодорхой санагдсан тул Харвардын их сургуулийн профессор Том Паттерсоны хувилбарыг энд авлаа. АНУ-ын төрийн тогтолцоо, бодит нөхцөл байдлын талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл профессор Том Паттерсоны www.edx.org онлайн сургалтын платформ дээр заадаг U.S Government хичээлийг судлахыг зөвлөө.
- ⁶ Баабар, Б.Цэнддоо, Д.Баярхүү, Х.Тэмүүжин нарын нийтлэл, бүтээлүүд бид хэн болох тухай олонтаа эргэцүүлдэг. Уянгын халил багатай, бодит байдалд ойр дүр зургийг тэд дүрсэлсэн санагддаг. Хамгийн сүүлд философийн доктор С.Одхүү “Монгол ментатитет” (2017) гэж ном гаргасан байна лээ.
- ⁷ Г.Дашрэнцэн гуайн “Манай сумын намууд” ёгт нийтлэлийг уншихыг хүсье. Та нулимсаа урстал инээнэ, гэхдээ ардчилсан институтүүд манай хөрсөнд хэрхэн мутацид орж болох тухай ёг хийсэн сэтгэгдэлтэй үлдэнэ.

 **WORLD WINE**
Prosecco Bar





ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.09.22-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР


Монгол улсад банкны салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойг тохиолдуулан Монголбанк санаачлан "Төлбөрийн тэнцэл ба гадаад өр" сэдэвт онол, практикийн бага хурлыг зохион байгуулсан. Энэ хурлаар Монгол улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2019 оны 2-р улирлын эцсийн байдлаар 29.7 тэрбум ам.доллар байгааг мэдэгдсэн.

Нийтийн гадаад өр (улсын өр) гэдэгт Засгийн газар, төрийн өмчит аж ахуйн нэгж, үйлдвэрийн газрууд, Төв банкны тавьсан өр, Засгийн газар болон Төв банкны гаргасан баталгааг багтаадаг. Монгол улсын өрийг эдийн засгийнхаа 40 хувийн түвшинд барих таазыг 2014 онд УИХ-аар олон хоног маргалдсаны эцэст 58.3 хувь болгож өндөрсгөсөн.

Одоогийн 29.7 тэрбум ам.долларын өрийн задаргааг харвал Засгийн газрын өр 7.2 тэрбум, Монголбанкных 2 тэрбум, арилжааны банкуудынх 2.3 тэрбум ам.долларт хүрсэн бол үлдсэн нь хувийн секторын өр төлбөр эзэлж байгаа аж.


Засгийн газрын гадаад өрийг зээлдүүлэгч улс болон валютаар харвал:

График 2. Засгийн газрын гадаад өр



2011 оны статистикийг сөхвөл МУ-ын нийт гадаад өр 10.9 тэрбум доллар байсан бол 2019 онд 29.7 тэрбум доллар болсон нь доорх графикаас харагдаж байна. Зээлдүүлэгчийн хувьд ихэнх нь донор орнуудын зээл болон Азийн Хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын зээл тусламж давамгайлсан үзүүлэлт харагдаж байна.

График 1. Монгол Улсын гадаад өрийн нөхцөл байдал



2012 онд Эвслийн Засгийн газар байгуулагдаж, нэгдүгээрт эдийн засгийн тэлэлтийн бодлого явуулна, хоёрдугаарт төр өөрөө тогтвортой байдлыг хангагч субъект гээд зарлачихсан. Ингээд 2012 оны 10-р сарын 25-нд шинэхэн УИХ чуулж "эдийн засгийг эрчимжүүлэх, урт хугацааны хөгжлийн хөрөнгө оруулалт хийх, экспортыг дэмжих бодлогыг санхүүжүүлэх зорилгоор" дунд, урт хугацааны 5 тэрбум хүртэлх ам.долларын Засгийн газрын үнэт цаасыг олон улсын зах зээлд үе шаттайгаар арилжаалах тогтоол гаргасан. Сар гаруйн дараа шинэхэн Засгийн газар олон улсын хөрөнгийн зах зээлд 1 тэрбум ам.долларын 10 жилийн бондоо 5.1 хувийн хүүтэй, 2013 оны 1-р сарын 5-нд 500 сая ам.долларын таван жилийн бондоо 4.1 хувийн хүүтэйгээр арилжиж байлаа. Уг нь зээл өгсөн тал нь аархаж үндэсний бахархлаа шингээсэн нэр өгдөг байтал зээл авч байгаа мөртлөө өрөө "Чингис" бонд хэмээн монголын засаг төр сүржин өргөмжилж байлаа. Чингис бондын араас Самурай, Өгөдэй, Хубилай, Дим сам, Мазаалай, Гэрэгэ гэсэн өрийг өрөөр дарсан бондууд гарлаа. Өрийг өрөөр дарсаар юунд хүрдгийг, энэ замаар хориод жил явсан Грек улс харуулж байгаа даа.

Бид Чингис бондын ихэнх хөрөнгөөр зам барьчихсан. Зээл авч зам барина гэдэг бол ухаангүй үйлдэл. Зээлийн хөрөнгөөр бүтээн байгуулалт буюу төмөр замын шинэчлэл, гол гол дэд бүтцийн шинэчлэлүүдийг хийж, бизнес эрхлэхэд таатай эко системийг үүсгэн байгуулах ёстой байсан юм. Тэгж байж өрийг өрөөр биш бизнесийн орлогоор төлж чадна.

Одоогийн эдийн засгийн чадамж энэ том өрнүүдээ цагт нь төлж чадахгүй.

МОНГОЛ УЛС ДИЖИТАЛ ШИЛЖИЛТЭД БЭЛЭН ҮҮ?

Монгол улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Оксфортын их сургууль, “Билл Мелинда Гэйтс” сан Аксес Сольюшинс ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй “Цахим эрин дэх Монгол улс” төслийн судалгааны тайлан, бодлогын зөвлөмжийг танилцуулах “Цахим эрин дэх нүүдэлчид” олон улсын бага хурал боллоо. Хуралд Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан болон төрийн байгууллагууд, технологийн салбарынхан, их, дээд сургууль, хувийн хэвшлийн төлөөлөл оролцсон.


“Цахим эрин дэх Монгол улс” судалгааг үндсэн 4 үзүүлэлтээр хийсэн байна лээ.

1. Дэд бүтэц буюу мэдээллийн технологийн зөөлөн болон хатуу дэд бүтэц МУ-д хэр нэвтэрсэн байгааг
2. Хүний нөөцийн бэлтгэгдсэн байдлыг. Хүний нөөцийг энгийн иргэд ба мэргэжлийн хүний нөөц гэж ангилж байгаа.
3. Санхүүгийн хүртээмж буюу мэдээллийн технологийн компаниудад санхүүжилт олох эдийн засгийн таатай нөхцөл байдал байгаа эсэхийг
4. Хууль эрх зүйн орчин мэдээллийн технологийн хөгжлийг хэр их дэмжиж байна вэ гэсэн үзүүлэлтүүдээр судалгааг хийжээ.

Энэ судалгааны багийнхан Монгол улс дижитал шилжилтэд БЭЛЭН гэсэн хариу гарсан гэж мэдээлсэн. Би мэдээллийн технологийн салбарын хүн л дээ, тиймээс энэ судалгааны хариуг бодитой гэж санал нийлж байгаа.

Манай улсын хүн ам 3.2 сая, тэдний 73 хувь нь хот, суурин газарт амьдарч байна. Нийгмийн сүлжээг 2.3 сая хэрэглэгч ашиглаж байгаа бол, гар утас эзэмшдэг 4 сая хэрэглэгчийн 2.8 сая нь үүрэн интернэт ашиглаж байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдээлснээр монголын хэрэглэгчид дөрвөн операторын (Mobicom, Unitel, Skytel, G-Mobile) 3G, 4G үйлчилгээгээр дамжуулан улс дотроо 2018 оны эхний хагас жилд нийт 27.3 терабит өгөгдөл (data) үүсгэсэн бөгөөд энэ тоо жилд дунджаар 25 хувиар өсч иржээ. Монголоос гадаад орнууд руу гурван оператороор (Mobicom, Gemnet, Мэдээлэл Холбооны сүлжээ ТӨХК) дамжуулан 140 Гбит/сек хурдтайгаар дата гаргадаг ажээ.

Дижитал үндэстэн байх нь монгол хүн бүрт ямар ашигтай болохыг иргэд сайн ойлгож мэдэх, амьдралын чанар, түвшингээ дээшлүүлэхэд ашиглах боломж, шаардлага өссөөр байна. Монголын дижитал хөгжлийн түвшин ямар байгааг 3i индексээр хэмжиж бусад оронтой харьцуулсан тайлан саяхан гарчээ. Facebook компаниас гаргаж буй Inclusive Internet Index (3i) 2019 буюу интернетийн хүртээмжийн индексээр Монгол улс



100 орноос 53-т оржээ. Индексийг 4 үзүүлэлтээр гаргажээ:

1. Интернэтийн олдцоор (availability) 57-д
2. Үнэ өртгөөрөө (affordability) 37-д
3. Хамаарлаараа (relevance) 52-т
4. Бэлэн байдлаараа (readiness) 85-д. Бэлэн байдал гэдэгт цахим тайлагдал, итгэл ба аюулгүй байдал, төрийн бодлого гэсэн гурван бүлэг үзүүлэлт ордог.

Израил улс 8 сая хүн амтай ч ДНБ нь 350-400 тэрбум доллар. ДНБ-ийг бүрдүүлж байгаа салбараар нь авч үзвэл өндөр технологийн бүтээгдэхүүнүүд буюу онгоц, харилцаа холбоо, компьютер, эмнэлгийн төхөөрөмж гэсэн бүгд технологи дээр суурилсан салбарууд байдаг. Бидэнд ч ийм боломж бий. Хүний нөөцийн хувьд ЕБС болон дээд боловсролын шинэчлэлийг хурдан эхлүүлэх хэрэгтэй. Старт-апуудад гайхалтай санаанууд байдаг ч түүнийгээ хэрэгжүүлэх хүний нөөц нь байдаггүй. Старт-ап компаниуд л энэхүү дижитал өөрчлөлтийг авчирна гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.*

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл

www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn
www.jargaldefacto.com